



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/01.

Өвт

Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан  
сэргийлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Малын эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэр Уугийн гол гэх газар Архангай аймгийн Цэнхэр сумын малчин өрхөд малын гоц халдварт шүлхий өвчин батлагдсан тул хил залгаа 46.796428N, 101.534731E, 46.7878 N 8 101.431138 E8 46679335 N, 101.391316 E8 46.855599 N8 101.597396 E, 46.84524 N, 101.605313 E цэгүүдийг тогтоож, малчин өрхийг жагсаалтаар баталсугай.

2. Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж ажиллах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Л.Батчулуун (Засаг даргын орлогч)  
Гишүүд: Р.Даваасүрэн (Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)  
Б.Батбилэг (Хустын рашаан мал эмнэлгийн эзэн)  
Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)  
Г.Баярсайхан (Жолооч)

3. Хил залгаа малчин өрхүүдийн малд эмнэлзүйн үзлэг хийж, дархлаажуулах ажлыг зохион байгуулахыг Хустын рашаан мал эмнэлгийн эзэн (Б.Батбилэг)-д даалгасугай.

4. Тухайн нутаг дэвсгэрийн өрхүүдийн байршил малын тоо, тархвар зүйн зураглал, мэдээлэл судалгааг гаргаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Р.Даваасүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

051101003

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/